

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН СЭТГЭЛГЭЭН ДЭХ ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ҮЗЭЛ САНАА

**МУИС, ОУХС-ийн профессор,
доктор (Ph.D) Ж.БОР**

Бидний үзэж буйгаар олон улсын харилцаа хөгжлийн 5 үе шатыг дамжин хөгжиж иржээ. Эхний үе шатыг нь "Бага бүс нутгийн олон улсын харилцаа" гэж томъёолж болно. Энэ нь зөвхөн хөршүүдтэйгээ л харилцах олон улсын харилцаа байлаа. Өөрөөр хэлбэл хөршийн цаадах хөршийн тухай ойлголт байхгүй гэсэн үг юм. Хоёрдох үе шатыг "Бүс нутгийн олон улсын харилцаа" гэж томъёолж болно. Энэ нь олон улсын харилцаанд гарч байсан дайн, байлдаан, худалдааны хөгжлийн явцад газар нутаг өргөжин тэлсэн, хөршийн цаадах хөршийн талаарх мэдээлэлтэй болсон, олон улсын харилцааны мэдээлэл нэмэгдсэнтэй холбоотой байлаа. Гурав дахь үе шатыг "Их бүс нутгийн олон улсын харилцаа" гэж томъёолж болно. Энэ нь олон улсын харилцааны хүрээнд өрнөсөн ард түмний их нүүдэл, түүнээс улбаалсан байлдан дагуулал, чөлөөт худалдааны сэтгэлгээ түгээмэлжсэнтэй холбоотой. Дөрөв дэх үе шатыг "Хуучин ертөнцийн олон улсын харилцаа" гэж томъёолж болно. Энэ нь Монголын байлдан дагуулал хуурай газрын 4/5 -ийг хамарч Pax Mongolica-г байгуулсантай ямар нэгэн хэмжээгээр холбоотой. Тав дахь үе шатыг "Дэлхий дахини харилцаа" гэж томъёолж болно. Энэ нь газар зүйн нээлт, колоничлолтой холбоотой.

Бидний хувьд одоо нэгэн асуудал сонин байна. Олон улсын харилцааны хөгжлийн эдгээр үе шатуудад Монголчууд, тэдний өвөг дээдэс хувь нэмрээ оруулж чадав уу үгүй юу? Энэ асуудлыг судалж үзэхэд монголчууд олон улсын харилцааны хөгжлийн 3, 4 дэх үе шатуудад онцгой үүрэг гүйцэтгэсэн байна. Өөрөөр хэлбэл, Их бүс нутгийн олон улсын харилцаа болоод хуучин ертөнцийн олон улсын харилцаа гарч ирэх, хөгжлийн үе шатны хувьд бүрэлдэн тогтоход гарамгай үүрэг гүйцэтгэсэн байна. Тухайлбал: хүнчүүдийн өрнө зүг нүүсэн нүүдэл нь:

Нэгд, олон улсын харилцааны бүс нутгуудыг холбон өгсөн. Ингэснээр олон улсын харилцааны хамрах хүрээг өргөтгөсөн;

Хоёрт, нүүдэлчдийн улс төрийн сэтгэлгээн дэх олон улсын харилцааны үзэл санааны ололт болсон чөлөөт худалдааны сэтгэлгээг тархаасан;

Гуравт, Төв Европоос Дундад Ази, Монголын өндөрлөг хүртэлх өргөн уудам нутагт гадаад бодлогын нэгэн ижил номлолтой, дипломатын нэгэн ижил ёс заншил, хэм хэмжээтэй улсуудыг багтаасан Pax Hunnica-г тогтоосон.

Мөн Их бүс нутгийн олон улсын харилцаа бүдгэрч эхэлсэн үед жужанчууд VI зуунд өрнө зүг нүүдэллэсэн хийгээд тэдний хойноос түрэгүүд гээг даран нэхэж, улс гүрнийхээ хилийг Кавказын нуруу хүртэл

тэлсэн явдал Их бүс нутгийн бүдгэрч байсан олон улсын харилцааг дахин сэргээхэд хүчтэй нөлөө үзүүлсэн юм.

Түрэгийн эзэнт улс мөхсөнөөс дотоод Евразийн Манжуураас Хар далай, гадаад Евразийн Хятадаас Энэтхэг хүртэлх Их бүс нутгийг хамарч тогтсон олон улсын харилцаа сулран буурахад хүрчээ.

Үүний улмаас өرنө, дорны худалдааны харилцаа гундан буурсаар түгжигдмэл байдалд орсон байлаа.

Нөгөөтэйгүүр Дундад Ази, Ойрхи Дорнодод өрнөж байсан хөлгүй их дайн дажин худалдааны сэтгэлгээг явцууруулах, чөлөөт худалдааг боймлон бсөгдүүлж байв. Ийнхүү чөлөөт худалдааг өргөн цараатай сэтгэх нүүдэлчдийн сэтгэлгээ маргагдахад хүрсэн байлаа.

Мөн шашин, шашнаар чөдөрлөгдсөн улс төрийн сэтгэлгээ энд тэндгүй газар авч, олон улсын харилцааг ойлгох хүн төрөлхтөний ойлголт явцуурч ядуурсан байв.

Ийнхүү олон улсын харилцааны хөгжил өргөн цараатай шинэ сэтгэлгээгээр дутагдаж, зогсонги байдалд арагшаа алхам ухарч уналтанд орсон үед монголчууд Евразийн зүрхнээс улс төр, олон улсын харилцаа, худалдаа, эдийн засгийн агуу их сэтгэлгээг тунхаглан зарлажээ.

Монголчуудын зохион байгуулсан байлдан дагуулал, олон улсын харилцааны өргөн уудам сэтгэлгээ хүн төрөлхтөнийг эзэмдсэн хуучин ядуу сэтгэлгээний хүрээг зад цохин устгасан төдийгүй олон улсын харилцааг шинэ өндөр шатанд гарган хөгжүүлж, эдийн засаг, худалдааг түгээмэлжүүлж, соёл иргэншлийн гол голомтуудыг зогсонги байдлаас гаргаж, нийт хүн төрөлхтөний сэтгэлгээг агуу их болгох үүд хаалгыг нээж өгсөн юм.

Дундад эртний монголчууд Чингис хааны үйл ажиллагаагаар дамжуулан олон улсын харилцаанд эрх зүйн дэвшилт шинж чанартай хэм хэмжээ, зарчмыг дэвшүүлэн гаргаж тавьсан юм. Тухайлбал:

1. Дайны эрх зүйн салбарт:

- дайныг урьдчилан зарлаж байж эхлэх зарчим;
- дайныг шударгаар хөтөлж явуулах зарчим;
- найрамдал заавал байгуулах зарчим;

2. Гадаад харилцааны эрх зүйн салбарт:

- эрх тэгш харилцах ёс;
- хүчээр түрээ үл барих зарчим;
- бусдын эрхшээлд эс өнгөлзөх ёс;
- гэрээ хэлэлцээртээ үнэнч байх ёс;
- төвийг сахин суугаа улс иргэнийг найрамдалтайгаар үзэх ёс;
- хил хязгаар дархан халдашгүй байх ёс;
- чөлөөт худалдааны зарчим;

3. Дипломатын эрх зүйн салбарт:

- элч төлөөлөгч дархан халдашгүй эрхтэй;
- дипломат элчийн дэв зэргийн ангилал /онцгой эрхт элчин, төлөөний элч, элч, элч - худалдаачин/ гэх мэт.

Эцэст нь монголын дипломат албаны бүтэц, уламжлал, залгамжлалын талаар хэдэн үг хэлэхийг хүсэж байна. Хүн улсын үеэс манай анхны дипломат алба зохион байгуулагдсаныг олон улсын харилцааны түүх шастир иотолж байна. Чухам тэр үеэс гадаад харилцаа хариуцсан байгууллагыг тодорхой албан тушаалын дэв зэрэгтэйгээр төрийн хэмжээнд зохион байгуулсан. Энэ нь төрийн яамны анхны болхи хэлбэр байлаа. Учир нь уул байгууллага бичгийн ба ёслолын гэсэн хоёр албанаас бүрэлдэж байсан. Энэ бол хариуцах ажлын хүрээг заагласан хэрэг мөн байлаа. Мөн гадаад бодлогын номлол, гадаад бодлогын чиг шугамын срөнхий гурван чиг боловсрогдсон байсан нь үүнийг давхар иотлон харуулж байна. Эдгээрийг дараа дараагийн Монгол төр улсууд уламжлан хөгжүүлсэн. Энд нэг онцлог харагддаг нь нэгэн удам угсааны улсуудад дипломатын ёс заншил хүчтэй уламжлагддаг явдал юм.

Author states that International relations went in its development through five stages, namely, as defined they are Sub-regional, Regional, Mega regional, ancient world, Globe wide. In his research the Mongolians played significant role in 3rd, 4th stages of the international relations.